



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 6/146

Хэрлэн сум

М.Дэлгэрзаяаг үргэлжлүүлэн
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн Малчинхүүгийн Дэлгэрзаяа нь хүүхэд асрах чөлөөнөөс хугацаанаас өмнө үүрэгт ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. М.Дэлгэрзаяагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч
	Х.Баярбаатар	Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн
	Д.Энхтуяа	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3.М.Дэлгэрзаяагийн үндсэн цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоон, 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тус тус тооцож, холбогдох бусад нэмэгдлийг олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.М.Дэлгэрзаяагийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, холбогдох тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

5.Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Дэлгэрзаяад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА